

**ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН
ГАДААДЫН ИРГЭН, ХАРЬЯАТЫН ГАЗРЫН ДЭРГЭДЭХ
САЛБАР ЗӨВЛӨЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ
ТОВЧ МЭДЭЭЛЭЛ**

(Хамрах хугацаа: 2022.01.06-2022.09.20)

2022.09.20.

Улаанбаатар хот

Нэг. Сул орон тооны сонгон шалгаруулалтын захиалгын тухай:

Төрийн албаны тухай хууль тогтоомжийн хүрээнд 2022 оны эхний 9 сарын байдлаар салбар зөвлөлөөс төрийн захиргааны гүйцэтгэх 11 албан тушаалын сонгон шалгаруулалтын захиалгыг Төрийн албаны зөвлөлийн Сонгон шалгаруулалтын газарт албан бичгээр хүргүүлж, ажлын 10 хоног байгууллагын болон Төрийн албаны зөвлөлийн цахим сайтаар нийтэд зарлуулж байна.

Хүснэгт-1

№	Захиалга хүргүүлсэн албан бичгийн огноо, дугаар	Сул орон тоо		Албан тушаалын нэр
		Удирдах албан тушаал	Гүйцэтгэх албан тушаал	
1	2022.03.01 №01		3	Өмнөд бүс дэх газрын мэргэжилтэн-2; Баруун бүс дэх газрын мэргэжилтэн-1.
2	2022.04.06 №02		1	Санхүүгийн хэлтсийн хөрөнгө оруулалт хариуцсан ахлах мэргэжилтэн-1;
3	2022.04.19 №03		1	Баян-Өлгий аймаг дахь хэлтсийн мэргэжилтэн-1;
4	2022.06.02 №04		3	Виз, зөвшөөрлийн газрын виз зөвшөөрлийн мэргэжилтэн-1; Гадаад харилцаа, хамтын ажиллагааны хэлтсийн гадаад харилцааны мэргэжилтэн- 1; Өмнөд бүс дэх газрын мэргэжилтэн-1.
5	2022.06.03 №06		1	Санхүүгийн хэлтсийн хөрөнгө оруулалт хариуцсан ахлах мэргэжилтэн-1;
6	2022.06.10 №07		2	Хяналт-шинжилгээ, үнэлгээ, аудитын хэлтсийн дотоод аудит хариуцсан ахлах мэргэжилтэн-1; Өмнөд бүс дэх газрын мэргэжилтэн-1.

Хоёр. Албан тушаалын тусгай шалгалт зохион байгуулсан тухай:

Төрийн албаны зөвлөлийн hh-admin.csc.gov.mn цахим системээр төрийн захиргааны удирдах 2 албан тушаалын сонгон шалгаруулалтын зарыг 2022 оны 01 дүгээр сарын 10-21-ний өдрүүдэд нийтэд зарлаж, 01 дүгээр сарын 24-25-ны өдрийн 09:00-17:00 цагт бүртгэлийг hh-admin.csc.gov.mn цахим системээр явуулсан.

Энэ удаагийн сонгон шалгаруулалт нь Төрийн албаны зөвлөлийн 2021 оны “Тогтоол хүчингүй болгох тухай” 410, “Хяналт шалгалтын мөрөөр авах арга хэмжээний тухай” 411 дүгээр тогтоолуудын хэрэгжилтийг хангах хүрээнд Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 14 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн албаны тусгай шалгалт авах болзол, журам”-д заасны дагуу энгийн горимоор буюу зарыг ажлын 10, бүртгэлийг 2-оос доошгүй хоногт зохион байгуулсан онцлогтой.

Салбар зөвлөлөөс тайлант хугацаанд албан тушаалын тусгай шалгалтыг 3 удаа зохион байгуулж, удирдах 2, гүйцэтгэх 7 албан тушаалд тэнцсэн иргэнийг тухайн албан тушаалд томиллоо. Харин томилохоос өмнө тэнцсэн иргэн өөр ажилд шилжсэн тул Санхүүгийн хэлтсийн хөрөнгө оруулалт хариуцсан ахлах мэргэжилтний 1 орон тоог дахин зарласан.

Хүснэгт-2

№	Тусгай шалгалт зохион байгуулсан огноо	Тоо		Тайлбар
		Удирдах албан тушаал	Гүйцэтгэх албан тушаал	
1	2022.01.28	2		Нөхсөн 2.
2	2022.04.06		3	Нөхсөн 3.
3	2022.05.04		1	Нөхөөгүй 1.
4	2022.07.06		6	Нөхсөн 4 Нөхөөгүй 2
ДҮН		2	10	

Гурав. Бусад үйл ажиллагааны талаар:

Төрийн албаны зөвлөлийн Гадаадын иргэн, харьяатын газрын дэргэдэх салбар зөвлөлийн 2021 оны жилийн тайлан, хавсралт судалгааг маягтын дагуу нэгтгэн 01 дүгээр сарын 12-ны өдрийн 01/190 дүгээр албан бичгээр Төрийн албаны зөвлөлд хүргүүлэв.

Төрийн албаны тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.1, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 1995 оны 109 дүгээр зарлигаар батлагдсан “Төрийн захиргааны албан хаагчийн тангараг өргөх ёслолын журам”, Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 59 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журам”-ын 3.1.5-д заасныг үндэслэн салбар зөвлөлийн даргын 2022 оны 01 дүгээр тогтоолоор тусгай шалгалтад тэнцэж, тухайн албан тушаалд жинхэлж томилогдсон 4 албан хаагчийг тангараг өргүүлэх ёслолын ажиллагааг Монгол Улсын Үндсэн хуулийн өдрийг тохиолдуулан 01 дүгээр сарын 13-ны өдрийн 11.00 цагт байгууллагын Хүндэтгэлийн танхимд зохион байгууллаа.

Төрийн албаны зөвлөлийн Гадаадын иргэн, харьяатын газрын дэргэдэх салбар зөвлөлийн 2022 оны анхны хурал 01 дүгээр сарын 26-ны өдрийн хурлаар дараах асуудлуудыг хэлэлцэж, байгууллагын даргын тушаал, салбар зөвлөлийн тогтоолоор тус тус батлуулсан.

- ✓ Салбар зөвлөлөөс 2021 онд хэрэгжүүлсэн үйл ажиллагааны тухай мэдээлэл;
- ✓ Салбар зөвлөлийн 2022 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний төсөл;
- ✓ Гадаадын иргэн, харьяатын газрын “Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх сургалтын болон ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах 2022 оны төлөвлөгөөний төслүүд.

Төрийн албаны зөвлөлийн 2021 оны “Тогтоол хүчингүй болгох тухай” 410, “Хяналт шалгалтын мөрөөр авах арга хэмжээний тухай” 411 дүгээр тогтоолуудын хэрэгжилтийг хангах, Сургалт судалгаа, мэдээллийн нэгдсэн сангийн газрын 2022 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн “Төрийн албаны зөвлөлийн 2021 оны 411 дүгээр тогтоолын хэрэгжилтийг хангах тухай” 06-05/226 дугаар албан бичгийн 1, 2 дугаар

хавсралт тогтоолын хэрэгжилтийн мэдээг нэгтгэн Төрийн албаны зөвлөлд 01/280 дугаар албан бичгээр хүргүүлэв.

Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 59 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журам”-д заасан үйл ажиллагааны тайлан хүргүүлэх чиг үүргийн дагуу Төрийн албаны зөвлөлийн Гадаадын иргэн, харьяатын газрын дэргэдэх салбар зөвлөлийн 2022 оны эхний хагас жилийн үйл ажиллагааны тайланг нэгтгэж, байгууллагын даргын 06 дугаар сарын 22-ны өдрийн 01/1156 албан бичгээр Төрийн албаны зөвлөлд хүргүүлэв.

Салбар зөвлөлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах хүрээнд албан хаагчдын цалингийн шатлалыг шинэчлэн тогтоох, зэрэг дэв шинээр олгуулах, ахиулах саналыг холбогдох байгууллагад хүргүүлсэн. Үүнд:

Байгууллагын хэмжээнд төрийн захиргааны 204 албан хаагч ажиллаж байгаа бөгөөд 2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний үнэлгээ, төрийн албанд ажилласан жил, тухайн албан тушаалын ангилалд ажилласан шаардлага, эрхэлж буй албан тушаалын ангилалд хамаарах зэрэг дэвтэй албан хаагчдын судалгааг нэгтгэлээ. Өнөөгийн байдлаар эрхэлсэн түшмэлийн 5, ахлах түшмэлийн 61, дэс түшмэлийн 77, нийт төрийн захиргааны 143 албан хаагч зэрэг дэв тогтоолгон, зэрэг дэвийн нэмэгдэл хувийг тооцуулан авч байгаа нь өмнөх оноос 1.6 хувиар өссөн байна.

Төрийн албаны тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2.3-т заасны дагуу дэс түшмэлийн зэрэг дэв олгуулахаар Хууль зүй, дотоод хэргийн яаманд 01/346, мөн хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2.2-т заасны дагуу эрхэлсэн түшмэлийн зэрэг дэвийг олгуулах саналыг Төрийн албаны зөвлөлд 01/345 дугаар албан бичгээр тус тус хүргүүлэв.

Үүний дагуу Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2022 оны А/87 дугаар тушаалаар 5 албан хаагчид дэс түшмэлийн зэрэг дэвийг шинээр, 48 албан хаагчийн зэрэг дэвийг ахиулан олгуулахаар шийдвэрлүүлсэн бөгөөд 07 дугаар сарын 01-ний өдрөөс зэрэг дэвийн нэмэгдлийг олгож байна.

Хүснэгт-3

	Эрхэлсэн түшмэл		Дэс түшмэл				Нийт
	Дэд зэрэг	Гутгаар зэрэг	Тэргүүн зэрэг	Дэд зэрэг	Гутгаар зэрэг	Дөтгөөр зэрэг	
Шинээр	-	-	-	-	-	5	5
Ахиулан	2	2	7	25	18	-	54
НИЙТ							59

Албан хаагчдын 2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө, хөдөлмөрийн гэрээний тайлангийн үнэлгээг харгалзан байгууллагын даргын 2022 оны Б/69 дүгээр тушаалаар төв болон орон нутаг дахь газрын нийт 67 албан хаагчийн цалингийн шатлалыг шинэчлэн тогтоосон бөгөөд "А буюу маш сайн" үнэлэгдсэн 7 албан хаагчийн шатлалыг алгасуулж, "В буюу сайн" үнэлэгдсэн 60 албан хаагчийн шатлалыг ахиуллаа.

Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл олгох журам”-ын дагуу Б/51, Б/8, Б/109 дүгээр тушаалаар нийт 13 албан хаагчид нэмэгдлийг, төвийн нэгжийн төрийн үйлчилгээний албан хаагчдын ажлын гүйцэтгэлийг улирлаар үнэлж, ур чадварын нэмэгдлийг нийт

2 удаагийн байгууллагын даргын тушаалаар, давхардсан тоогоор 65 төрийн үйлчилгээний албан хаагчдад 10-25 хувийн нэмэгдлийг тооцож тус тус олгуулсан.

Мөн Засгийн газрын 2022 оны “Үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн цалингийн доод хэмжээг тогтоох тухай” 107 дугаар тогтоол, Засгийн газрын 2022 оны “Тогтоол, тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай” 192 дугаар тогтоолын дагуу үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн цалингийн доод хэмжээг өөрчилсөнтэй холбогдуулан төв, орон нутаг дахь нэгжийн албан тушаалын цалингийн сүлжээний 1-4 дэх шатлалаар цалинждаг нийт 33 албан хаагчийн албан тушаалын цалинг Б/155 дугаар тушаалаар шинэчлэн тогтоолоо.

Хүснэгт-4

№	Төрөл	Албан хаагчийн тоо	Хувь
1	Төрийн үйлчилгээний албан хаагчид ур чадварын нэмэгдэл	65 /давхардсан/	10-25
2	Төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл	13	5-25
3	Илүү цагийн нэмэгдэл хөлс	2	-
4	Цалингийн шатлал ахиулсан	67	-
Нийт		82	-

Тайлант хугацаанд сахилгын шийтгэл авсан албан хаагчдын судалгааг гаргаж, хүний нөөцийн мэдээллийн системд оруулсан. Үүнд: өөрт нь хаалттай хэлбэрээр сануулах 2, нийт ажилтанд нээлттэй хэлбэрээр сануулах 7, албан тушаалын цалин бууруулах 7, ажлаас халах 1, нийт 17 албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулсан.

Хүснэгт-5

№	Сахилгын шийтгэлийн төрөл	Төв		Орон нутаг	
		ТЗ	ТҮ	ТЗ	ТҮ
1	Өөрт нь хаалттай хэлбэрээр сануулах	-	-	2	-
2	Нийт ажилтанд нээлттэй хэлбэрээр сануулах	-	-	6	1
3	Албан тушаалын цалин бууруулах	3	1	3	-
4	Ажлаас халах	1	-	-	-
Нийт		2	1	10	1
		17			
Сахилга, хариуцлагын талонг цоолж сануулсан		2	-	2	-

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН
ГАДААДЫН ИРГЭН, ХАРЬЯАТЫН ГАЗРЫН ДЭРГЭДЭХ
САЛБАР ЗӨВЛӨЛ